


БАТЛАВ.

ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ ТӨРИЙН
ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

 Ц.БАТСАЙХАН

ҮХЭР СҮРГИЙГ ЯЛГАН ТЭМДЭГЛЭЖ, МАЛЫН ҮНДЭСНИЙ БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БҮРДҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

1. ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Монгол Улсын малын тоо сүүлийн жилүүдэд өссөөр 2023 онд 64.7 сая толгойд хүрлээ. Малын тоо өсөх нь малчдын амьжиргаанд сайн нөлөөтэй ч улсын эдийн засаг, байгаль орчныг хамгаалах үйлсэд төдийлөн сайн нөлөө үзүүлэхгүй байна. Манай улсын бэлчээр олон жилийн дунджаар 75-80 сая хонин толгой малыг жилийн 4 улирлын турш тэжээлээр хангах нөөцтэй ч өнөөдрийн байгаа мал нь хонин толгойд шилжүүлснээр 120 гаруй сая болж бэлчээрийн даац 1.5-1.6 дахин хэтрээд байна. Бэлчээрийн даац нь хүн малын нягтрал ихтэй, хатуу болон зөөлөн дэд бүтэц сайтай бүс нутагт 3-5 дахин хэтэрсэн үзүүлэлттэй байна. Ийнхүү бэлчээрийн даац хэтрэлт нь уур амьсгалын өөрчлөлтийн зарим хүчин зүйлстэй нэгдэн газрын доройтолд орж “Монголын” гэж нэрлэгдэх шар шороон шуургыг үүсгэн Ази тивийн бусад улс орнуудад тараад байна.

Бэлчээрийн даацад тохирсон тооны мал сүрэг өсгөн үржүүлэх, тооны өсөлтөөс чанарт шилжиж, мал, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх нь мал аж ахуйн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, ган зуд зэрэг байгалийн аюулгүй үзэгдлээс урьдчилан сэргийлэх, малчид, иргэдийн амьжиргааг хамгаалах төрийн бодлого, үйл ажиллагаа хэмээн “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тодорхойлогдсон.

Монгол улсаас мал, махны худалдан авагч гадаад улсууд нь олон улсын мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын стандарт, протоколыг үндэслэн мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний худалдаандаа мөрдлөг болгон ашигладаг.

Мал сүргийг ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэснээр малын удам гарваль, гарал үүслийг тодорхой болгож, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн мөшгөх, шилжилт хөдөлгөөнийг бүрэн хяналтад авах боломж бүрдэж, малын удмын сан, генийг хадгалах, хамгаалах, малын хулгайгаас урьдчилан сэргийлэх, алдагдсан малыг бүртгэлээр дамжуулан олох зэрэг ач холбогдолтой.

Малд ялган тэмдэглэгээ хийж, бүртгэснээр зөвхөн эрүүл малын махыг хэрэглэх төдийгүй хэзээ, хэн, хаанаас ямар малын мах хэрэглэж байгааг урьдчилан тооцоолох, хэн гэдэг хүний хэдэн төрлийн хэчнээн толгой мал хаана отор нүүдэл хийж явааг мэдэх төдийгүй малын чанар удам угсааг мөн энэхүү бүртгэлээр дамжуулан мэдэх боломжтой юм.

Ингэснээр мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлж, үйлдвэрлэлийн процессыг хянаж импортлогч улсын шаардлагыг хангах

боломжийг олгоно. Малыг бүртгэж, мэдээллийн санг бүрдүүлэх нь зөвхөн малын үржлийн ажлыг удирдан зохион байгуулах бус эдийн засаг, худалдааны олон улсын шаардлагыг хангах томоохон түлхүүр болж байна.

2. ЭРХЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын үндсэн хуулийн 5.5-д “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна” гэж заасан мал тус бүрийг хувийн дугаараар бүртгэж төрийн хамгаалалтад авч, түүний үйлдвэрлэл, худалдааны үр өгөөжийг нэмэгдүүлнэ. Мал сүргийг төр хамгаалах зорилгоор 2018 онд Малын генетик нөөцийн тухай хуулийг баталсан. Хуулиар малыг ялган тэмдэглэж, нэгдсэн бүртгэлд хамруулах ажлыг нарийвчлан дараах байдлаар заасан байдаг. Үүнд:

5.1.1 Малыг бүртгэл

5.2 Малыг үл давтагдах хувийн дугаараар ялган тэмдэглэж, бүртгэнэ.

5.3 Малыг бүртгэлд малчны нэр, хаяг, бүртгэлийн дугаар, малын байршил, төрөл, удам, гарваль, нас, хүйс, үүлдэрлэг байдал, өсөлт, хөгжилт, сүргийн нөхөн үйлдвэрлэл, ашиг шимийн гарц, чанар, эрүүл мэндийн үзүүлэлт, маллагааны хэлбэр, шилжилт хөдөлгөөн, шаардлагатай бусад мэдээлэл хамаарна.

5.7 Малыг генетик нөөцийн мэдээллийг нэгтгэх, ашиглах, хянах, олон улсын болон бүс нутгийн мэдээллийн сүлжээтэй мэдээлэл солилцох, хэрэглэгчийг мэдээллээр хангах үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүтцийн нэгж хариуцна.

18.2. Малыг генетик нөөцийн үйл ажиллагааны дараах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:

18.2.1. малын генетик нөөцийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, үндэсний генийн санг бүрдүүлэх, ажиллуулах;

Дээрх хууль зүйн зохицуулалтаас гадна Улсын их хурлын тогтоолоор баталгаажсан бодлогын баримт бичгүүдэд малыг бүртгэх, мэдээллийн санг бүрдүүлэх, тогтвортой ашиглах арга хэмжээг тусгасан байдаг. Тухайлбал:

- УИХ-ын 2022 оны 36-р тогтоолоор баталсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний” төлөвлөгөөний 4.1.2-д “Малд үзлэг, ангилалт хийх, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх, удам зүйн үнэлгээ хийх замаар малын ашиг шимийн үзүүлэлтийг тодорхойлох, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх”

- УИХ 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.4.2-т “Үржлийн хээлтүүлэгч, цөм сүргийн хээлтэгч, төвийн бүсийн үхэр сүргийн малыг ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлнэ” гэж тус тус заасан.

3. МАЛЫН ҮНДЭСНИЙ БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Малын генетик нөөцийн тухай хуулийн 5.7-д заасны дагуу Малыг үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэн мал аж ахуйн салбарт нэвтрүүлэн салбарын бүх шатны төрийн болон хувийн нэгжүүд ашиглан ажиллаж байна.

Нэгдсэн сангийн систем нь технологийн хөгжилд нийцүүлэн 100% цахимаар ажилладаг бөгөөд <https://livestock.mofa.gov.mn/> хаягаар орж малын бүртгэлийг хийдэг. Системийг 2022 онд хүлээн авч улсын хэмжээнд нэвтрүүлэн 2023 онд нэмэлт хөгжүүлэлтийг хийгээд байна. Мөн 2023 оны 01 дүгээр сараас эхлэн Сүүний урамшууллын мэдээллийн сан, Мал эмнэлгийн гэрчилгээний нэгдсэн сантай холболт хийн малчин, мал бүхий өрх малаа борлуулахаар гэрчилгээ бичигдсэн үед тухайн өрхийн малын тооноос шууд хасалт хийх байдлаар уялдуулан хөгжүүлэгдсэн.

Малчин, мал бүхий өрх, мал аж ахуй эрхлэгч /фермер/-ийн ерөнхий мэдээлэл болон нийт малын тоо толгойг системийн Үндсэн бүртгэл хэсэгт хийдэг. Жишээ нь:

Малчин, мал бүхий өрхийн:

- Эцэг эхийн нэр
- Өөрийн нэр
- Регистрийн дугаар
- Малчны төрөл
- Малчны код
- Харьяалагдах хаяг
- Утасны дугаар
- Малын тоог зэрэг мэдээллийг бүртгэдэг. Малын ерөнхий бүртгэлийг хийхдээ:
 - Малын төрөл
 - Нас
 - Хүйс
 - Анги
 - Ангилагдаагүй
 - Хэрэгцээний
 - Үржлийн сүрэг
 - Цөм сүрэг
 - Ээмэглэсэн эсэх зэргээр дэлгэрүүлэн бүртгэдэг.

Ээмэгтэй малын жагсаалт:

Малыг ялган тэмдэглэж, нэгдсэн санд бүртгэснээр мал тус бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг хөтлөх бүрэн боломж нээгддэг. Үүнд:

- Малын төрөл
- Ээмэгний дугаар
- Нас
- Хүйс
- Үүлдэр, омог
- Малчны ерөнхий мэдээлэл
- Мал сүрэгт хийсэн үзлэг ангилалтын ерөнхий мэдээлэл
- Мал эмнэлгийн үйлчилгээнд хамрагдсан эсэх

Малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн системд улс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, хувийн аж ахуй нэгжийн түвшинд хязгаарлагдмал эрхтэй хандаж ажилладаг байдлаар хөгжүүлсэн. Аймгийн түвшинд аймаг, нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газрын 22 мэргэжилтэн тухайн орон нутгийн хэмжээнд мэдээллийг нэгтгэсэн байдлаар хариуцдаг. Харин сумын түвшинд сум, дүүргийн хөдөө аж ахуйн

тасгийн 365 мэргэжилтэн анхан шатны бүртгэлийг хөтөлж мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хариуцан ажилладаг. Өөр хэлбэл аймагт 1, суманд 1 бүртгэгч чиг үүргийн дагуу хариуцан ажилладаг гэж хэлж болно.

Манай улсын хэмжээнд малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээ эрхэлдэг хувийн 184 нэгж малчинтай гэрээ байгуулан системд мал бүртгэх эрхтэйгээр хандан ажилладаг.

4. ХАМРАХ ХҮРЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 424 дүгээр тогтоолоор мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс байгуулахаар батлагдсан Ховд, Баян-Өлгий, Увс, Хөвсгөл аймгийн бүх сум, Дорнод аймгийн Халхгол сумын үхэр сүргийг бүрэн ялган тэмдэглэж бүртгэлд хамруулна. (хүснэгт 1)

1. Ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх үхэр сүргийн байршил, тоо

№	Аймгийн нэр	Сумын тоо	Нийт үхрийн тоо
1	Баян-Өлгий	13	149,198.0
2	Ховд	17	166,764.0
3	Увс	19	191,029.0
4	Хөвсгөл	23	468,615.0
5	Дорнод	1	24,394.0
	Нийт	73	1,000,000.0

5. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт тусгаарлагдсан эрүүл бүс байгуулахаар батлагдсан 5 аймгийн 73 сумын нийт 1 сая үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулах ажлыг хийж гүйцэтгэнэ. Энэ ажил нь дараах 3 ажилбараас бүрдэх бөгөөд тус бүрдээ тусгайлан аргачлал, техник, технологийг шаардана. Үүнд:

1. Үхрийг ялган тэмдэглэх хэрэгсэл бэлтгэх
2. Үхрийг ялган тэмдэглэх (ээмэглэх)
3. Малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд ялган тэмдэглэсэн үхрийн тухай мэдээллийг оруулж, бүртгэх, баталгаажуулах

5.1. Бод малын ялган тэмдэглэх хэрэгсэл (ээмэг) бэлтгэх

Бод малын ялган тэмдэглэх хэрэгсэл болох ээмэг нь Малын ээмэг 6996:2023 Ерөнхий шаардлага улсын стандартыг болон дараах шаардлагыг хангасан байна.

№	Малын ээмэг	Техникийн ерөнхий шаардлага
1	Гарал үүсэл:	Аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.
2	Үйлдвэрлэгчийн нэр, хаяг:	2.1. Үйлдвэрлэгчийн нэр хаягийг бичнэ. 2.2. Үйлдвэрлэгчийн тодорхойлолт 2.3. Барааг нийлүүлэх тохиолдолд зөвшөөрсөн баримт бичиг
3	Стандартын шаардлага:	Малын ээмэг Ерөнхий шаардлага MNS 6996:2023 стандартыг хангасан байна.

4	Тавигдах тусгай шаардлага:	<p>4.1. Ээмгэнд шивэгдсэн хувийн дугаар, зураасан кодын системд хувиргахад ямар ч төрлийн ухаалаг төхөөрөмжийн камер, унших төхөөрөмжөөр уншуулахад саадгүй хувийн дугаар уншигдахаар тод шивэх. /бүдэг бол ашиглагдахгүй/</p> <p>4.2. Ээмэгний загвар нь Малын ээмэг Ерөнхий шаардлага MNS 6996:2023 стандартын "B" хавсралтын "1-р загвар"-тай нийцсэн байна.</p> <p>4.3. Ээмэгний 4 булан өнцөггүй мөлгөр байна.</p> <p>4.4. Ээмэг нь -45 хэмээс +45 хэм хүртэл температурт ашиглах боломжтой байна.</p> <p>4.5. Ээмэг нь малд зүүхэд унахааргүй бөх, бат түгжигддэг хийцтэй байх бөгөөд эм талын төгсгөл хэсэг задгай байна.</p>
5	Ээмэгний бүтэц:	<p>5.1. Ээмэгний эр хэсгийн цоологч үзүүр нь мохож үрэгдэхгүй байна.</p> <p>5.2. Ээмэг нь малын хувийн дугаар болох 10 оронтой тоо, түүнийг агуулсан зураасан бар кодтой байна.</p> <p>5.3. Малын хувийн дугаар, зураасан кодыг ээмэгний эр талын хэсэгт заавал бичнэ.</p>
6	Ээмэгний түүхий эд материал:	<p>6.1. Ээмэг нь уян хатан, гаднын нөлөөнд тэсвэртэй, өндөр чанарын полиуретан материалаар хийгдсэн байна.</p> <p>6.2. Сайн чанарын полиуретан түүхий эдээр ээмэг үйлдвэрлэснийг баталсан нотлох баримттай байна.</p> <p>6.3. Ээмэгний материалыг холбогдох лабораториор шинжлүүлсэн дүгнэлттэй байна.</p>
7	Өнгө:	Тод шар өнгөтэй байна
8	Хэмжээ:	<p>8.1. Ээмэгний өндөр 60 мм байна.</p> <p>8.2. Ээмэгний өргөн 45 мм байна.</p> <p>8.3. Ээмэгний шилбэ 17 мм байна.</p> <p>8.4. Ээмэгний эм талын диаметр 28-30 мм-ээс ихгүй байна.</p> <p>8.5. Ээмгэнд бичигдэх үсэг, тооны өндөр 10-14 мм байна.</p> <p>8.6. Зураасан кодын өндөр 8 мм -ээс багагүй байна.</p>
9	Бичигдэх үсэг, тоо:	<p>9.1. Захиалагчийн өгсөн ээмэгний эр талд бичигдэх тоо, үсгийг зураасан кодын системд оруулан тод хэвлэн ирүүлсэн байна.</p> <p>9.2. Бичилт нь лазерын технологиор хэвлэгдсэн байна.</p>
10	Санал болгох биет загварын ээмэг:	Санал болгож буй ээмэгний биет загварыг заавал ирүүлнэ.
11	Ээмэгний загвар:	Санал болгож буй ээмэг нь үйлдвэрлэгчийн хэвлэн гаргасан катологи дахь ээмэгний загвар үзүүлэлттэй тохирч байх

Ялган тэмдэглэх хэрэгслийг /ээмэг/ ажил гүйцэтгэгч төсөвт өртөгт багтаан үйлдвэрлэх эсвэл худалдан авч бэлтгэнэ. Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн систем <https://livestock.mofa.gov.mn> цахим хуудсаар дамжуулан Малын ээмэг 6996:2023 Ерөнхий шаардлага стандартад нийцсэн малын ялган тэмдэглэх хэрэгслийг /ээмэг/ захиалга хийнэ. Ажил гүйцэтгэгч нь захиалагчаас олгосон хязгаарлагдмал эрхийг ашиглан дээрх цахим системээс ээмгэнд бичигдэх дугаарыг авна. Цахим системээс олгогдсон дахин давтагдашгүй дугаарыг ажил гүйцэтгэгч ээмэг бүрд лазерын технологи ашиглан тодоор шивж бэлтгэнэ.

5.2. Үхрийг ялган тэмдэглэх (ээмэглэх)

Малын генетик нөөцийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-д мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний мэргэжлийн байгууллага малыг ялган тэмдэглэхээр заасан байдаг. Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх байгууллага гэж мал үржүүлгийн үйл ажиллагаа явуулахаар улсын бүртгэлд бүртгүүлсэн хувийн мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгж гэж ойлгоно. Энэхүү тендер шалгаруулалтад оролцогч нь дээрх үйлчилгээ үзүүлэгч мэргэжлийн байгууллага бус бол үхэр сүргийг ялган тэмдэглэх ажлыг түншлэлийн хэлбэрээр гүйцэтгэж болох бөгөөд энэ тохиолдолд ээмэглэх үйлчилгээний зардлыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А-68 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний төрөл, төлбөрийн жишиг үнийн хэмжээ”-г мөрдөж тендерийн үнийн саналд тусгана. Хэрэв түншлэлийн хэлбэрээр оролцох бол тухайн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай хамтран ажиллах гэрээтэй байхыг заавал шаардана.

5.3. Ялган тэмдэглэх технологит хугацаа:

Монгол орны цаг уурын нөхцөлд байдлаас хамааран үхрийн чихэнд ээмэг бэхлэх хугацааг 04 дүгээр сарын 15-аас 06 дугаар сарын 05-ны хооронд тогтоосон. Үхэр бүртгэлийн ажлыг 2024 оны 03-05 дугаар сарын хооронд нийт 50 хоногийн хугацаанд гүйцэтгэнэ. Ажил гүйцэтгэгч нь үхэр ялган тэмдэглэх хугацаатай уялдуулсан календарьчилсан төлөвлөгөөтэй байна. Дээрх хугацаанд багтаан үхэр ээмэглэх ажил гүйцэтгэх төлөвлөгөөг ажиллах хүчин, багаж, техник хэрэгсэл, үхрийн тарга тэвээрэг зэрэг хүчин зүйлстэй уялдуулан бодиттой боловсруулсан байна.

5.4. Ялган тэмдэглэхэд зайлшгүй шаардлагатай багаж хэрэгсэл:


Ажил гүйцэтгэгч нь үхэр сүргийг ялган тэмдэглэж, бүртгэлд хамруулахад шаардлагатай дараах тоног төхөөрөмж, техник хэрэгсэлтэй байна. Үүнд:

№	Тоног төхөөрөмж, техник хэрэгслийн нэр	Зориулалт
1	Хамардагч	Үхрийг барих, хөдөлгөөнгүй зогсоох
2	Бахь, зүү	Үхэрт ээмэг зүүх зориулалтын бахь зүүний хамт байна. Нэг бахиар 1000 үхэр ээмэглэх боломжтой ч үхрийн зогсолт, хөдөлгөөн зэргээс шалтгаалан 1000-аас цөөн тооны үхэр ээмэглэх тохиолдол байдгийг харгалзан бэлтгэл хангахыг анхаарах
3	Ээмэг	Малыг ялган тэмдэглэх, бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох зорилготой бөгөөд Малын ээмэг MNS 6996:2023 стандартын шаардлага хангасан байна. (дэлгэрэнгүйг ээмгэнд тавигдах шаардлага хэсэг болон дээрх стандартаас үзнэ үү)
4	Толгой хавчигч	Үхрийг барьж, хөдөлгөөнгүй зогсоох зориулалттай бөгөөд хөдөлмөр хөнгөвчлөх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах ач холбогдолтой.
5	Бүртгэл хийхэд шаардагдах техник хэрэгсэл (компьютер, таблет, гар утас, утас цэнэглэгч, повер банк, цахилгаан үүсгүүр гэх мэт)	Малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд ялган тэмдэглэсэн үхэр сүргийн мэдээллийг оруулах болон техник хэрэгслийг тасралтгүй ажиллагааг хангахад шаардлагатай хэрэгсэл

Дээр багаж, хэрэгслээс гадна орон нутагт ажиллах унаа, шатахуун, ажлын хөлс, татвар, хураамж зэрэг зардлыг үнийн саналд багтаан тооцно.

5.5. Малыг ялган тэмдэглэх заавар:

Стандартын шаардлага хангасан ээмгийг үхрийн зүүн талын чихэнд зүүнэ. Ингэхдээ ээмгийг ээмэглэгч бахинд бэхлээд үхрийн чихний судасгүй хэсэгт (зурагт үзүүлсний дагуу) цоолж бэхэлнэ.



5.6. МҮБМНС-д ялган тэмдэглэсэн үхрийг бүртгэх, баталгаажуулах

Малыг ялган тэмдэглэсэн даруй Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэснээр баталгаажилт хийгдэнэ. Бүртгэлийг 2 аргаар хийнэ.

А) Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн (<https://livestock.mofa.gov.mn>) цахим системээр бүртгэнэ. Бүртгэлийг үндсэн бүртгэл хэсгийн малчин, мал бүхий өрх бүрийн малын тоон мэдээллээр бүртгэнэ.

Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн цахим системээр бүртгэл хөтлөх заавар:




1. *Livestock.mofa.gov.mn* цахим системд нэвтрэх эрх авсны дараа нэвтрэч орно.
2. **Үндсэн бүртгэл хэсгийн Малчин/Ферм** модуль цэсрүү орно. Тус модульд харьяалагдах аймаг, сумын нийт малчин, мал бүхий өрхийн мэдээллүүд гарч ирнэ.
3. *Нийт малчин, мал бүхий өрх дотроос малын бүртгэл хийх малчин өрхийн мэдээллийг сум, багаар сонгон хайж болох ба Малчны нэр/регистрийн дугаарыг хайлтын хэсэгт оруулан хайлт хийж болно.*

4. Ингэснээр хайж буй малчны мэдээллийг хурдан шуурхай олох боломжтой ба тухайн малчны нэрийн баруун талд байрлах **Малын тоо харах хэсэгт** дарснаар малчны ерөнхий мэдээлэл хэсэгт шилжинэ.
5. Ерөнхий мэдээлэл хэсэгт малчны хаяг байршил, идэвхтэй эсэх болон нийт малын тоо, төрөл харагдана.
6. Малын төрөл хэсгээс Жишээ нь: **Үхэр 50** гэсэн тоог дарсан бол хамгийн дор байрлах хэсэгт мал **нийт үхэр сүрэг анги чанар, хүйс, ээмэгтэй, ээмэггүй** гэж задарна.
7. **Ээмэггүй мал** дээр дарж ээмэгжүүлсэн малын тоогоор **ээмэгтэй малын жагсаалтруу** шилжүүлэг хийнэ.
8. Шилжүүлэг хийхдээ ангилалтын төрлийг сонгож ээмэгжүүлэлт хийсэн нийт малын нас хүйсийг тааруулж шилжүүлэх малын тоог бичиж шилжүүлэг хийнэ.
9. Ингэснээр **Ээмэгтэй малын жагсаалт хэсэгт** ээмэглэсэн малын мэдээллийг оруулах боломжтой талбар гарч ирнэ. Тус талбарт /малын төрөл, төрсөн огноо, нас, хүйс, хээлтүүлэгч эсэх, үрийн донор эсэх, ангилал, үүлдэр, ашиг шимийн чиглэл, төлөв, баталгаажсан үүлдэр, омгийн мал эсэх, ээмэгний дугаарын төрөл, ээмэгний дугаар оруулах, зүс, содон тэмдэг, эцэг малын ээмэгний дугаар, эх малын ээмэгний дугаар, зураг/ зэрэг мэдээллийг оруулах боломжтой.
10. Дээрх талбарт "Малын бүртгэлийн хүснэгтэд" бичсэн мэдээллийг оруулснаар **Үндсэн бүртгэл хэсгийн Ээмэгтэй малын жагсаалтад** шууд бүртгэгдэнэ.

Б) Малын бүртгэлийг гар утасны аппликейшн ашиглан хялбаршуулсан байдлаар гүйцэтгэж болно. Ингэхдээ "LHIS" мал аж ахуйн систем аппликейшныг гар утсандаа татаж суулган, бүртгэгч тус бүрээр малын бүртгэл үүсгэх эрхийг урьдчилан ХХААХҮЯамны МААБХЗГ-ын МГНХ-с авсан байх шаардлагатай.

Гар утасны аппликейшн ашиглан малын бүртгэл хийх заавар:

1. Ухаалаг утасны аппликейшн татах хэсгээс **Мал аж ахуй-NLIMS** гэсэн нэртэй аппликейшныг хайж ухаалаг төхөөрөмждөө суулгана.
2. Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн системд бүртгэгдсэн **нэвтрэх эрхийг** хийж аппликейшнд нэвтрэн орно.
3. Тус аппликейшныг сүлжээгүй үед ашиглах тохиолдолд урьдчилж мэдээлэл татах шаардлагатай тул мэдээллийг интернэт сүлжээтэй үед татахыг анхаарна уу!!!
4. Урьдчилж мэдээлэл татахад интернэттэй үед аппликейшн хэсэгт нэвтрэхэд зүүн дээд буланд байрлах = тэмдэглэгээ дээр дарснаар **Лавлах мэдээлэл татах** гэсэн цэс гарч ирнэ.
5. Лавлах мэдээлэл татах хэсэгт дарснаар **Үндсэн мэдээллээ урьдчилан татах уу?** Үгүй / Тийм гэсэн сонголтоос **Тийм** гэсэн сонголтыг хийнэ.
6. Ингэснээр **Мэдээлэл амжилттай татагдлаа** гэсэн мэдээлэл ирнэ.
7. Дараагийн үйлдлээр = хэсэгт байрлах **Гэрээт сумууд** гэсэн хэсгийн баруун буланд байрлах ✎ тэмдэглэгээ дээр дарснаар **Гэрээт сумууд** гарч ирнэ.

8. Сум бүрийн харалдаа **Малчин татах** гэсэн хэсэгт дарж баруун буланд байрлах  тэмдэглээ дээр дарж тухайн суманд харьяалагдах нийт малчдын мэдээллийг татна.
9. Нийт малчдын мэдээлэл дээр байрлах **хайлт хийх** хэсэгт малчны регистрийн дугаарыг бичсэнээр малчны ерөнхий мэдээлэл гарч ирнэ. /Энэ үеэс эхлэн интернэтгүй үед ашиглах боломж бүрдэнэ/
10. Ерөнхий мэдээллийн дор нийт малын тоо, төрлөөрөө задарч харагдана.
11. Баруун доод буланд байрлах **Ээмэглэлт бүртгэх** хэсэгт дарснаар **малын төрөл, нас, хүйс, зүс содон тэмдэг, үүлдэр, баталгаажсан үүлдэр омог эсэх, ээмэгний төрөл, ээмэгний дугаар, эцэг, эх малын хувийн дугаар гэх мэт хэсгүүдийг Сонголт хийх зарчмаар бөглөнө.**
12. **Жич:** Ээмэгний дугаар сонгох сонголтын зүүн талд  байрлах зурагт дарснаар ухаалаг төхөөрөмжийн камер  ашиглан ээмгэнд шивэгдсэн зураасан кодыг уншуулахад тус ээмгэнд шивэгдсэн **хувийн дугаар** шууд орж ирэх боломжтой.
13. Малын бүртгэлийг хийж дуусгаснаар буцах товчны тусламжтай буцаж дараагийн өрхийн малыг бүртгэх болон интернэт сүлжээ орсны дараа **мэдээлэл илгээх хэсэгт дарж мэдээлэл илгээснээр Livestock.mofa.gov.mn цахим хуудаст мэдээлэл илгээгдэж Ээмэгтэй малын жагсаалтад бүртгээгдэнэ.**
14. Нэг удаад илгээх үйлдэлд 50 малын мэдээллийг илгээх боломжтой ба нийт ангилсан малыг илгээснээр Livestock.mofa.gov.mn цахим системд харагдах болно.

Цахим систем ашиглан бүртгэл хийх боломжгүй болсон тохиолдолд хавсралтад заасан “Малын бүртгэл хийх хүснэгт”-ыг ашиглан нэг бүрчлэн үхэр сүргийн мэдээллийг хөтөлж тэмдэглэнэ. Уг бүртгэлийн мэдээллийг цахим системийн ажиллагаа хэвийн хангагдахад системд шивж бүртгэнэ. Мал сүргийг ялган тэмдэглэж, бүртгэсэн мэдээлэл нь Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн- Үндсэн бүртгэл хэсгийн- Ээмэгтэй малын жагсаалтад уг бүртгэл орсноор **Баталгаажсан** гэж үзнэ.

6. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХАНГАМЖ:

Мал сүргийг ялган тэмдэглэх ажил нь хүн хүч ихээр шаарддаг, цаг агаарын янз бүрийн нөхцөлд ажилладаг онцлогтой. Үхэр ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх ажлыг багаар гүйцэтгэхээр тооцсон бөгөөд багт мал баригч, ээмэглэгч, бүртгэгч туслах ажилтан заавал байхаар тооцно. Эдгээрээс мал ээмэглэгч, бүртгэх ажил гүйцэтгэх багийн гишүүн нь заавал мал зүйч эсвэл түүнтэй адилтгах мэргэжилтэй байна. Ажил гүйцэтгэгч нь малын үндэсний бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг мэргэжлийн талаас нь удирдаж чиглэл өгөх үүрэгтэй бүхий зөвлөхтэй байна. Зөвлөх нь магистр болон түүнээс дээш эрдмийн зэрэгтэй, мал зүйч түүнтэй адилтгахуйц мэргэжилтэй, мэргэжлээрээ 10-аас дээш жил ажилласан, тэргүүлэхээс дээш мэргэшлийн зэрэгтэй байна.

Дээрх ажиллах хүчний хүснэгт нэг аймгийг нэг менежерийн ахалж ажиллах бөгөөд уг менежер нь аймгийн үхэр сүргийн тоо, сумын тоо, малчин өрх хоорондын зай зэргээс хамааран тухайн аймагт ажиллах хүн хүчний нөөцөө бүрдүүлэх шаардлагатай. Нэг баг нь нэг өдөрт 150 толгойгоос цөөнгүй үхрийг ялган тэмдэглэж,

бүртгэлжүүлэх бөгөөд үхэр ээмэгжүүлэх ажил гүйцэтгэх хугацаа нь 50 хоног байна. Өөрөөр хэлбэл ажил гүйцэтгэгч нь нэг өдөрт нийт 21.9 мянган үхэр ээмэглэхээр төлөвлөн ажлын баг, ажиллах хуваарь хийж ирүүлнэ. Ингэхдээ тухайн багийн бүрэлдэхүүнд заавал хүснэгтэд дурдсан мэргэжлийн хүмүүс ажиллахаар тооцон үйлчилгээний хөлсийг төлөвлөнө.

Малыг ялган тэмдэглэж, бүртгэх ажлыг хийж гүйцэтгэх 1 багийн хүний нөөцөд тавигдах шаардлага:

Үндсэн ажилтан	Мэргэжил	Мэргэжлээрээ ажилласан жил	Боловсролын түвшин	Туршлагын шалгуур үзүүлэлт
Мал баригч	-	1	шаардахгүй	Мал маллаж байсан туршлагатай хөдөлмөрийн насны, иргэн байх
Ээмэглэгч	Мал зүйч (түүнтэй адилтгах)	1	Бакалавр	Бод малын ангилагч, шинжээчийн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх
Бүртгэгч		2		Малын бүртгэл хөтлөх сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх

7. АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ ХИЙХ ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ

Ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон орон нутагт аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн алба, хяналтын алба, сумдын Хөдөө аж ахуйн тасгийн албан хаагчид хамтран гүйцэтгэнэ. Захиалагчийн хяналтыг ялган тэмдэглэх хэрэгсэл авах үед, орон нутагт ээмэглэх ажил гүйцэтгэх үед болон малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэл хийх үед тус тус хэрэгжүүлнэ.

8. АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ҮЗҮҮЛЭХ ЗАХИАЛАГЧИЙН ДЭМЖЛЭГ

Ажил гүйцэтгэгчид захиалагч дараах дэмжлэгийг үзүүлнэ. Үүнд:

1. Аймаг, сумын холбогдох төрийн байгууллагатай холбож шаардлагатай мэргэжил, аргагүйн дэмжлэг үзүүлэх;
2. Малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд хандах хязгаарлагдмал эрх олгоно;
3. Малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн тогтмол хэвийн ажиллагааг хангана.

